

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чогсомын Ишдовдон

Он сар өдөр, төрсөн газар	1913, Дундговь аймгийн Баянжаргалан сум
Үндсэн сүм хийд	Уулын мамбын хийд
Б.Ринченгийн сүм, хийдийн нэр	Уул мамбын хийд, Уулын хурал
Ярилцлаганд дурдагдсан бусад сүм хийдүүд	Зүүн жанжин Чойрын хийд



- 2007 оны 7 сарын 30-нд Дундговь аймгийн Баянжаргалан суманд Гандантэгчилэн хийдийн тэргүүн лам Чогсомын Ишдовдон гуайтай уулзаж байна. За одоо яриагаа эхэлье. Энэ ажиллаж байна, дуу хурааж эхэлсэн.

- Баянжаргалан сумын нутаг дэвсгэр дээр эртний ямар хурал хийдийн газар байсан бэ?

Тэр Их газрын чулууны урд талд Уулын мамба гэж хийд байсан. тэр чинь манай хийд байсан юм.

- Аан, бид нар очсон. Их газрын чулууны баруун урд гурван дуганы туурь байна лээ.

Өө, за тэр чинь, тэр чинь мөн дөө. Урдаа нэг дуган, хойноо зэрэгцээ хоёр дуганы туурь байх ёстой.

- Нэг маарамба лам хэдэн шавьтайгаа сууж байсан гэж нутгийн нэг хүн ярьж байсан?

За за, тийм байх. Тэр ч их шажин хаагдахын дөнгөж өмнөх үе болов уу...

- Тэр баруунтаа нэг суварганы туурь байсан уу?

Аа мэдэхгүй. Суварга байсан байлгүй дээ.

- Энэ танай шинэ хийд хэдэн онд байгуулагдсан бэ?

1992 онд байгуулагдсан.

- Тэр үед настай өвгөн лам нар олон байв уу?

Арваад өвгөн лам нар байсан.

- Анхны хамба лам нь ямар хүн байв?

За, энэ түүхийг яривал бас их сонин. Манай хийдийн анхны ерөөлийг Зүүн чойроос лам нар ирж хурж байсан юм байна. Тиймээс эхэндээ Зүүн чойрын харъяа гэж манай хийд хурал явж байж. Энэ үед Зүүн Чойрын их гэвш Дампил гэж лам, гэсгүй Содов лам нар ахалж байсан юм. За, Зүүн Чойроос арваад настай өвгөд лам нар, манайхаас арваад өвгөд багачуул нийлээд нэг хориод лам хувраг цуглаж хурал эхэлсэн. Ингээд дараа нь одоо энэ Дэлгэрцогтын өвгөн, өө, нэр нь алга боллоо... хэн билээ... Бид Шар өвгөн гэдэг байсан юм. Гэлэн хүн, их настай хүн тэр хүн тэргүүлж байсан юм. Тэгээд өвгөн 4-5 жилийн өмнө хот руу шилжээд явсан. Тэгээд би л одоо хийдээ хариуцах болсон. Ер нь одоо энэ манай хийдэд Лодой, Агваандорж, Самбуу, Зундуй, Лувсандорж, Норовренчин, Доржжамц гээд арваад өвгөн байсан юм. Одоо цөөрсөн дөө. Тэгээд одоо би нэг өвгөнтэйгөө л үлдэж дээ. Лодой маань Чойрт, Агваандорж маань Дэлгэрцогтод, нэг өвгөн маань хэвтэрт орсон. Яахав, миний гараар орж, айлд нэг сан уншихчаан болсон гурван бандитай. Нэг нь

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хойшоо хот руу Шашны дунд сургуульд явсан. Бас нэг номтой, номгүй жижиг гурав дөрвөн юм бий. Тийм л юм даа. За тэгээд би нэг иймэрхүү долоон найман бандитай л хүн. Цуглахаараа нэг долоо наймуулаа цугладаг юм. Уг нь тэр би Зүүн Чойрт хурал тогтмол хурж байхад очиж суудаг л байсан. Одоо ч больж, Зүүн Чойр маань ламгүй болж байна. За нэг иймэрхүү.